



БАГАНУУР ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар 8/327

Улаанбаатар хот

Явган хүний замыг сэргээн засварлах
ажлыг хүлээн авах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн “Дүүргийн 2023 оны төсөв батлах тухай” ээлжит ХХ хуралдааны 38 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Явган хүний замыг сэргээн засварлах ажилд хяналт тавьж, хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Дэмчигжав

(Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга)

Гишүүд:

Д.Төгсгэрэл

(Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн мэргэжилтэн)
Э.Алтангэрэл

(Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)

Д.Энхбаатар

(1 дүгээр хорооны Засаг дарга)

Б.Мөнхнаран

(3 дугаар хорооны Засаг дарга)

Н.Гунгаажав

(Өнгөт харш ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга:

2. Ажлын хэсэгт ажиллахаас өмнө ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаар мэдэгдэл, тайлбар гаргахыг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Уг ажлыг холбогдох хууль журам, стандарт норм дүрэмд нийцүүлэн хүлээж авахыг Ажлын хэсэг (Д.Дэмчигжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.ДАВААСҮРЭН

